



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/580

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад  
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан Хүнс, ногооны агуулахын барилга, 500 тн барилгын ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)  
Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Цолмонбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Д.Аюушжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Г.Даваадорж ("Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн Ерөнхий инженер)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын ЗДТГазрын дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн, архитектор)

Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын геодезийн мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Ганхуяг ("Стийл проект" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

М.Очирхуяг ("Өсөх Нум" ХХК-ийн захирал)

Захирамж-2023

6712011261

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ж.Балдандорж ("Дэлгэр шимт хөрс" хоршооны дарга)

Комиссын нарийн бичгийн дарга:

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Н.Шинэбаяр) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

